



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Г Элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох
шинжилгээний зардлын даатгалын сангаас
төлөх төлбөрийн дээд хязгаарыг тогтоох тухай

Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Улсын Их Хурлын байнгын хорооны 2000 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм” (орон тооны бус)-ийн 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээнд эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх нэг удаагийн зардлын төлбөрийн дээд хязгаарыг хагас автоматаар тодорхойлоход 80.000 /наян мянга/ төгрөг, бүрэн автоматаар тодорхойлоход 120.000 /нэг зуун хорин мянга/ төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2. Батлагдсан төлбөрийн дээд хязгаарыг баримтлан, даатгуулагчаас нэмэлт төлбөр гаргуулахгүй ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга /захирал/ нарт үүрэг болгосугай.

3. Элэгний С вирусийн идэвхжил тодорхойлох эрх бүхий эрүүл мэндийн байгууллагатай даатгалын гэрээ байгуулан, даатгуулагчийн хоёр хүртэлх удаагийн шинжилгээний зардлын төлбөрийг нь гүйцэтгэлээр нь тооцон санхүүжүүлэх, холбогдох програм хангамжид өөрчлөлт оруулах, дээрх тусlamж, үйлчилгээг даатгуулагчдад хөнгөн шуурхай үзүүлж, олон нийтэд сурталчилан, хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Батбилэгт/-нд даалгасугай.

